



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/530

Есөнбулаг

Захиалгат сургалтад хамрагдах
цэцэрлэгийн эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 35 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.3, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.5 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тэргүүний цэцэрлэгүүдийн туршлага судлах, сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанар, арга зүйг сайжруулах, багш нарыг чадавхжуулах зорилгоор Боловсролын ерөнхий газрын Сургуулийн өмнөх боловсролын хэлтсээс зохион байгуулж байгаа захиалгат сургалтад хамрагдах Есөнбулаг сумын цэцэрлэгийн эрхлэгчдэд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 6,500,000 (зургаан сая таван зуун мянга) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөрийн холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

